



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 10 дугаар сарын 28

Дугаар 4

Улаанбаатар хот

IV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 15.00 цагт Төрийн ордон дахь "Чингис хаан танхим"-д 09 хувийн ирцтэй хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар (Мал, амьтны гоц халдварт өвчний нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ)

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Х.Болорчулуун*

2. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүн

*Эрчим хүчний дэд сайд,
М.Баярмагнай*

3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, мутацилагдсан шинэ хувилбар болон эрүүл мэндийн салбарын бэлэн байдлын талаар

*Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал,
Ц.Билэгтсайхан*

4. Улсын онцгой комиссын Шуурхай бүлгийн томилолт, зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний талаар

*Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга,
дэд хурандаа Т.Баярхүү*

5. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэлийн Онцгой комисс, бүх шатны Засаг дарга нарт:

1.1. Өвөлжилт хүндэрч болзошгүй зарим аймгийн малчид, иргэдэд төрийн болон эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ хүрэхгүй байхаас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.2. Малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэх, зохион байгуулалт, ажлын уялдааг сайжруулах;

1.3. Олон улсын нөхцөл байдалтай холбогдуулан стратегийн болон өргөн хэрэглээний хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад шаардлагатай бараа материал, түүхий эдийн хомсдол, тасалдал үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;

1.4. Цаг уурын байгууллагаас гаргаж буй бэлчээрийн даац, зудын эрсдэлийн мэдээ, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн талаарх зарлан мэдээллийг ард иргэдэд шуурхай хүргэх, болзошгүй байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх;

1.5. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 277 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 09 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах;

1.6. Малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийг Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээ, санамж бичгийн үндсэн дээр маршрут гарган мал эмнэлгийн үзлэг, шинжилгээ, гэрчилгээнд үндэслэн зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

1.7. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээнд малаа бүрэн хамруулж, батлагдсан маршрутын дагуу отрын мал сүргийг дайран өнгөрүүлэх, мал эмнэлгийн цахим гэрчилгээг үндэслэн эрүүл мал оторлуулах, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;

1.8. Аймаг, сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх;

1.9. Намар, өвлийн отор, малын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх болон өвчний хор уршгийн талаарх мэдээлэл, сурталчилгааны ажлыг орон нутгийн түвшинд хэвлэл

мэдээллийн хэрэгсэл, цахим орчноор дамжуулан малчид, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад тогтмол хүргэх ажлыг зохион байгуулах;

1.10. Бусад аймгийн нутаг дэвсгэрт отроор явж буй малчин өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, мэдээлэл солилцох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, малчид, иргэдтэй хамтран аливаа эрсдэлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.11. Гамшгийн хор уршгийг арилгах чиглэлээр сумдад үүссэн өр төлбөрийг яаралтай шийдвэрлэх;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын онцгой комиссын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан нарт:

2.1. Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангахад шаардагдах сэлбэг, материал, тоног төхөөрөмжүүдийг Улсын стратегийн нөөцийн жагсаалтанд нэмж оруулах, холбогдох хөрөнгийг 2023 оны Улсын төсөвтэй уялдуулан шуурхай зохион байгуулж, шийдвэрлэх;

Гурав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Мал, эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

3.1. Малын гоц халдварт өвчин гарсан аймаг, сум, багийн голомтын болон сэжигтэй бүсийн эрсдэлтэй нутгийн зураглал гаргаж, олон нийтэд танилцуулан, эрт сэрэмжлүүлэг анхааруулга өгөх;

3.2. Хээлтүүлэгч малын бэлтгэн нийлүүлэлтийн ажлыг мал эмнэлгийн лабораторийн шинжилгээнд хамрагдаж, эрүүл мэндийн үзлэгт орсон эрүүл хээлтүүлэгчийг гоц халдварт өвчингүй эрүүл бүс, нутаг, малчны сууриас бэлтгэх талаар зөвлөмж чиглэл хүргүүлэх;

3.3. Мал сүргийн тоо толгойн өсөлт, бэлчээрийн даац, хадлан, тэжээлийн хүрэлцээ хангамжтай уялдуулан мал, махны экспортыг нэмэгдүүлэх, импортлогч улсын холбогдох яам, мэргэжлийн газруудтай мал экспортлох гэрээ, хэлцэл хийж, орон нутгийн байгууллагуудыг бодлого, зохицуулалтаар дэмжиж ажиллах;

3.4. Экспортын махны дээжийн шинжилгээг тухайн орон нутагт нь хийх боломжийг бүрдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Дөрөв. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:

4.1. Гамшгийн улмаас учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, цаг хугацаа алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор өвөлжилт хүндэрч болзошгүй баруун аймгийн малчдад улсын нөөцөөс өвс, тэжээл тодорхой нөхцөлтэйгээр олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх.

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод:

5.1. Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бигэр, Завхан аймгийн Тэлмэн, Баянтэс, Ховд аймгийн Алтай сумдын Эрүүл мэндийн төвийн автомашиныг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлж ажиллах;

Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нарт:

6.1. Эрчим хүчний эх үүсвэрүүдийн нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай нүүрс тээврийн вагон хангалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүүд даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

